

УЗЭ-ийн лимфоцитар үрэвсэл (lymphocystic interstitial pneumonia-LIP) гэсэн хэлбэрүүдийг багтаан авч үздэг.



Зураг 1. ¹ УПТӨ-уушгины паренхимийн тархмал өвчин, ² LAM-лимфангиолейомиоматоз.

УПТӨ-ий бүлэгт шалтгаан тодорхой (холбогч эдийн системийн өвчнүүд, орчны болон эмийн нөлөөгөөр үүссэн) болон шалтгаан тодорхой бус (УЗЭ-ийн шалтгаан тодорхой бус үрэвсэл, саркоидоз), гранулематоз (саркоидоз г.м.) болон бусад өвчнүүд (LAM, Лангхансын эст гистиоцитоз, эозинофилт гранулём) ордог.

УЗЭ-ийн шалтгаан тодорхой бус үрэвсэлтэй өвчтөнийг үнэлэх нь

УЗЭ-ийн шалтгаан тодорхой бус үрэвслийн оношийг тогтоох нь динамик үйл явц бөгөөд эмчлэгч эмч, дүрслэл оношлогооны эмч, эмгэг сулаач эмч нарын нягт холбоотой үйл ажиллагаан дээр үндэслэгдэнэ. Эмнэлзүй, рентген, эмгэг морфологийн шинжүүдийн үндсэн дээр оношийг зөв тогтоох хүртэл эмчилгээ хийхийг азнах хэрэгтэй.

УПТӨ-ий оношийг зовиур, анамнез, үзлэг, цээжний рентген зураг, уушгины үйл ажиллагааны сорилын шинжилгээ зэрэг дээр үндэслэн тогтооно (зураг 2). Эмнэлзүйн үнэлгээнд өвчний эхний шинжүүд (ихэвчлэн амьсгаадах, ханиах), тэдгээрийн даамжрах байдал, явц, хавсарсан өвчнийг (тухайлбал, холбогч эдийн системийн өвчин, дархлал хомсдох өвчин) тодруулах хэрэгтэй. Мөн орчны бохирдол, тоосны нөлөөнд автсан эсэх, тамхи татдаг эсэх, хорт хавдрын улмаас эмчлэгдэ байсан эсэх, эмийн хэрэглээ, мэргэжлийн болон хорт бодис, тэдгээрийн үргэлжилсэн хугацаа, гүйцэтгэдэг ажил, удамшлын анамнез зэргийг нарийвчлан асуух нь онош тавихад ач холбогдолтой юм.

Хүснэгт 1